

**АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ  
ГЭРЭЭ**

2013 оны 05 дугаар  
сарын 15-ны өдөр

дугаар АӨҮА-2013/12/74

Улаанбаатар  
хот

**Ерөнхий зүйл**

Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Ашигт Малтмалын Газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас XV-007438 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хотын Үндэсний татварын ерөнхий газарт бүртгэлтэй, аж ахуйн нэгжийн 9011172076 тоот гэрчилгээ, 5267552 регистрийн дугаартай “Налгар хөндий” ХХК (цаашид Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэнэ) нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 078 тоот тушаалаар батлагдсан Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмыг үндэслэн Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Хадат гүний зэс-молибен-алтны үндсэн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үеийн хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг.Гэрээний нөхцөл, хугацаа**

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - a. Гүйцээх хайгуулын ажлыг хийж нөөцийг болон нөөцийн зэргийг өсгөж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх;
  - b. Гидрогеологи, инженер геологийн судалгаа хийх;
  - c. Технологийн туршилтыг хийлгэх;
  - d. Ордын нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулах;
  - e. Уурхай барьж байгуулах;
2. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг 2016 оны 04 дүгээр сарын 20-ны дотор АМГ-т ирүүлнэ.
3. Ордын технологийн туршилтын хугацаа 3 жил байна.
4. Орд ашиглах төслийн хүчин чадалд хүрэх хугацаа 3 жил байна.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

*Ameluu*

49

5. Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Хадат гүний зэс-молибен-алтны үндсэн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдөр дуусгавар болгоно.

### Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт нөхөн төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахаас өмнө Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд ашиглалтын үед хийж гүйцэтгэх дараахь ажлын зөвшөөрлийг авсан байна. Үүнд:
  - а. Газар эзэмших зөвшөөрөл, гэрээ;
  - б. Усны гэрээ;
3. Ашигт малтмалын тухай хуулийн 48-д заасныг үндэслэн АМГ-ын даргын 2009 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан АМГ-ын ГСХ-ийн “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн хайгуулын ажлын жилийн тайлан хүлээн авах, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг тооцох” дотоод зааврын дагуу жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хайгуулын ажлын тайланг ГСХ-т хүргүүлж хайгуулын ажлын доод хэмжээг баталгаажуулж, хуулбарыг гэрээний биелэлтийн тайлангийн хамт гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ( 1 ) жил тутам УУСХ-т ирүүлнэ.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлттэй холбоотойгоор АМГ-аас үзлэг, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрлэлийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.
6. Орд ашиглахтай холбогдсон баримт бичгийг Монгол хэл дээр үйлдсэн байна.
7. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд гарч байгаа зардлуудыг татварын албанд тушаасан тухай мэдэгдлийг тайланд тусгасан байна.

8. Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

#### Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай хүсэлтийг бичгээр хүргүүлнэ.
2. Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.
3. Гэрээний заалтуудын биелэлтэд үзлэг, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.

#### Дөрөвдүгээр зүйл. Бусад зүйл.

1. Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтанд хүлээн авсан комиссын дүгнэлт, шийдвэр (гэрээний заалтууд бүрэн биелсэн акт)-ийг үндэслэн гэрээлэгч талууд хамтран дүгнэж акт үйлдэнэ.
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагаврыг бүрэн хариуцна.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг АМГ-тай хамтран дүгнээгүй тохиолдолд ашигт малтмалын XV-007438 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Гэрээг 3 /гурав/ хувь үйлдсэн бөгөөд 1 /нэг/ хувийг АМГ-ын Уул уурхайн асуудал хариуцсан нэгжид, 1 /нэг/ хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 /нэг/ хувийг кадастрын бүртгэлийн төвийн архивт тус тус хадгална.

6. Энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарах маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Ашигт малтмалын газрыг төлөөлж:  
Уул уурхайн хэлтсийн даргын  
үүргийг тур орлон  
гүйцэтгэгч.....С. Баттулга



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:  
“Налгар хөндий” ХХК-ийн захирал  
..... Л.Энхбат



*Handwritten signature*

46

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгэл хийгдэж байгаатай холбогдуулан нэг талаас Ашигт малтмалын газар /цаашид АМГ гэх/, нөгөө талаас Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Хадат гүний зэс-молибденийн ордын XV-007438 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн эзэмшигч “Налгар хөндий” ХХК-тай байгуулсан №АӨҮАГ-2013/12/74 тоот гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн (№АӨҮАГ-2013/12/74) тоот гэрээний салшгүй хэсэг байна.

1 Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Хадат гүний зэс-молибденийн ордын талбайн ашигт малтмалын хайгуулын XV-007438 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдөр дуусгавар болно.

2. Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг үндсэн гэрээ байгуулах үед мөрдөж байсан хуулийн дагуу төлөх буюу төлбөрийн хэмжээ 1 гектар тутамд 1.5 америк доллар байна.


3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийг мөрдөж ажиллана.

4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнд оруулах энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн хавсралтанд шинэчлэн бүртгүүлсэн тухай тэмдэглэгээ хийлгэнэ.

Ашигт малтмалын газрыг төлөөлж:

Уул уурхайн хэлтсийн дарга

..... С.Баттулга



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

“Налгар хөндий” ХХК-ийн захирал

..... Л.Энхбат



АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ  
ДҮГНЭСЭН ТУХАЙ АКТ №2016/8

2016.04.11

Нэг талаас АМГ, нөгөө талаас Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Суман хад нэртэй талбайд орших XV-007340 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Налгар хөндий” ХХК нар 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн №АӨҮА-2013/12/74 тоот гэрээний биелэлтийг хамтран дүгнэвэл:


1. Орд ашиглах ТЭЗҮ боловсруулах ажил:

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Суман хад нэртэй газар орших Хадат гүний зэс молибден, алтны ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг “Эрдэнэс инженеринг” ХХК-аар хийлгүүлэхээр 2016 оны 02 сарын 25-ний өдөр 02/02 тоот гэрээ байгуулан ажиллаж байна.

2. Хадат гүний ордын зэс-молибден-алтны анхдагч хүдрийн дээжийг баяжуулах технологийн туршилт, Хадат гүний зэс-алтны үндсэн ордын исэлдсэн хүдрийн технологи туршилтын ажлыг Геологийн төв лаборатори 2013 онд хийж гүйцэтгэсэн байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авсны дараа Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах боломжтой гэж үзэн гэрээний үүргээ биелүүлсэн талаарх баримт бичгийг үндэслэн гэрээг хамтран дүгнэв.

АМГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:  
УУЛ УУРХАЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
С. БАТТУЛГА



“НАЛГАР ХӨНДИЙ” ХХК-ИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:  
ЗАХИВАЛ  
Л. ЭНХБАТ



Боловсруулсан:

УУХ-ийн мэргэжилтэн

*J. Ojirija*

Г. Оюунтуяа

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN